

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны нэгдүгээр сарын 29-ны 14 цаг 08 минутад эхэлж, 14 цаг 49 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 41 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Тагнуулын ерөнхий газрын 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/237 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга Батын Хурцыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн томилох.2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 12-т "... Балданжавын Ариунсан" гэснийг "...Батын Хурц " гэж өөрчлөх.3. "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Б.Хурцад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын</p>

		<p>2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/117 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга Бадамдоржийн Саруулыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 12-т "...Отгонбаатарын Адъяа " гэснийг ".....Бадамдоржийн Саруул" гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Саруулд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Пүрэвжавын Золжаргалыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 5-д "...Цэрэндашийн</p>

		<p>Батзориг” гэснийг “...Пүрэвжавын Золжаргал " гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга П.Золжаргалд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Бусад асуудал: "Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай</p>	<p>"Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцээд, "Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-ийн 2.7, 3.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулан, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ